



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/438  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

### Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



**МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН  
ЛАБОРАТОРИ ТӨААТҮГ-ЫН  
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга Тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг:  
[Naranchimegts@audit.gov.mn](mailto:Naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 260512  
Цахим хаяг:  
[Sambuunyamyia@audit.gov.mn](mailto:Sambuunyamyia@audit.gov.mn)

Ахлах аудитор: Н.Батсайхан  
Утас: 260512  
Цахим хаяг: [batsaikhann@audit.gov.mn](mailto:batsaikhann@audit.gov.mn)

Багийн ахлагч: П.Ариунаа  
Утас: 96660444  
Туслах ажилтан: Н.Цэдэнсодном

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй  
дүүрэг, Жуулчны гудамж Капитал  
центр 10 давхар 1005 тоот

Цахим хаяг: [info@confidenceaudit@mn](mailto:info@confidenceaudit@mn)  
Утас: 322431, 70119100  
Факс: 70139100

**Аудитын тайлан**

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, 18.5 дах зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-/2017/18/СТА-ТШЗ аудитыг “Конфиденсе аудит” ХХК хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн завсар үеийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 13-наас 2016 оны 10 дугаар сарын 21 хүртэл шалгасан, 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дугаар сарын 16-наас 2017 оны 3 дугаар сарын 9-ний хооронд хийхээр төлөвлөн аудитын багийн ахлах аудитор М.Ундрах, туслах ажилтан Н.Цэдэнсодном нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори хүрээлэн ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 22-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

“Конфиденсе аудит” ХХК аудитыг 2017 оны 01 дугаар сарын 16-наас 2017 оны 3 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захиралд гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, дотоод журам, зааварт өөрчлөлт орсон байна. НББ-ийн тухай хууль 2016 оны 1 дүгээр сарын 1-нд шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Хүнс хөдөө Аж Ахуйн яамны дэргэдэх “Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори” ТӨААТҮГ нь Монгол улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн болон бүртгүүлэхээр санал болгож буй эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд баталгаажуулалтын дүгнэлт гаргах, малын эмийн үйлдвэрлэл явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Монгол Улсын Мал эмнэлгийн үйлчилгээг Фармакопейн шаардлага хангасан эм, биобэлдмэлээр найдвартай тогтвортой хангах, мал эмнэлгийн эмийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх гол зорилтыг тодорхойлсон байна.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд балансын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-A-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим болон нарийвчилсан 37 сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-B-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх тусгайлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 2016 онд боловсруулсан байна.

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-B-2/

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

### **Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт байхгүй бөгөөд эрсдэлийг төлөвлөлтийн үе дунд байна гэж тооцсон.

### **Материаллаг байдал:**

Тус байгууллага төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар учраас өөрийн орлогоор санхүүжиж, зарцуулдаг байна. Материаллаг байдлын түвшинг нийт хөрөнгийн 0.2 хувиар тооцож үзэхэд 2,164.9 мянган төгрөг болж байна.

### **Шилэн дансны мэдээлэл**

2016 онд нийт 988,046.3 мянган төгрөг бүхий 502 гүйлгээ гарснаас 5,000.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй цалингаас бусад 447,763.1 мянган төгрөг бүхий 27 гүйлгээ байна. Үүнээс шилэн дансны бүртгэлд 435,017.9 мянган төгрөг бүхий 24 гүйлгээг шилэн дансны хуулийн дагуу бүртгэлд тусгаж 52,760.8 мянган төгрөг бүхий 3 гүйлгээг шилэн дансны бүртгэлд оруулаагүй байна.

### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 16 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан 37 горим, сорил гүйцэтгэв.

### **Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй.

### **Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:**

1. Мөнгөн хөрөнгө. Зардлын анхан шатны баримтын бүрдэлт 521.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн зөрчил илэрсэн. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зардлын анхан шатны баримтын бүрдэлтийг цаашид анхаарч шаардлага хангасан баримтаар ажил гүйлгээг бүртгэж байхыг нягтлан бодогчид анхааруулж зөвлөсөн.

2. Байгууллагын санхүүгийн тайланд 2016.01.01-ээр ХХОАТ-ын өглөг 380.1 мянган төгрөг, хувь хүнээс суутгасан албан татварын өглөг 686.5 мянган төгрөг байгаа боловч татварын мэдээгээр ХХОАТ-ын авлага 1,297.4 мянган төгрөг, хувь хүнээс суутгасан албан татварын авлага 297.8 мянган төгрөг байна. Нийт зөрүү 2661,8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: Тайлант үеийн аудитаар залруулж татварын өглөг, авлагын үлдэгдлийг тохируулж байх зөвлөмж өгсөн.

3. Цалингийн тооцооллоос 2016 оны 4-9 дүгээр сард Улсын шалгагч 1 ажилтны НДШ-н даатгуулагчаас суутгах нийт 313.3 мянган төгрөг суутгаагүй байсан.

Шийдвэрлэсэн: Аудитаар залруулж 2016 оны 12 дугаар сард нөхөн тайлан өгч ажилтнаас авлага үүсгэсэн.

4. Цалингийн тооцооллоос ХХОАТ-ыг ойролцоогоор 576.3 мянган төгрөгөөр дутуу, амралтын мөнгө тооцоолохдоо хоол унааны нэмэгдлийн нэмж бодсон ба үүнээс ХХОАТ-ын өглөг 103.7 мянган төгрөг, НДШ-ын 113.2 мянган төгрөг илүү суутгасан ба 1,150.5 мянган төгрөгөөр илүү цалин олгосон байна.

Шийдвэрлэсэн: Ажилчин нэг бүрийн амралтын мөнгийг байх ёстойгоор нь дахин тооцоолж үзээд 2017 оны 2-р сарын цалингаас суутган авч үлдэхийг зөвлөсөн.

#### **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулаагүй алдаа гараагүй.

#### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

#### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,440.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 3,551.4 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 1,888.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд 1 зөвлөмж тайлант онд хэрэгжиж 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Мал Эмнэлгийн Эмийн Сорилт Баталгаажуулалтын Улсын Лаборатори ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тодруулга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн Сайдын баталсан бодлого аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.



# **МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН ЛАБОРАТОРИ ТӨААТҮГ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

## **Менежментийн захидал**

### **Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:**

|                                  |   |
|----------------------------------|---|
| Асуудал 1                        |   |
| Татварын үлдэгдлийн талаар ..... | 2 |
| Асуудал 2                        |   |
| ХАОАТ-ын тооцооллын талаар ..... | 3 |

## **Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Мал Эмнэлгийн Эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Мал Эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори ТӨААТҮГ байгууллагын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

|                                              |                                  |
|----------------------------------------------|----------------------------------|
| <b>Асуудал 1: Татварын үлдэгдлийн талаар</b> | <b>Тэргүүлэх ач холбогдол №3</b> |
|----------------------------------------------|----------------------------------|

**ҮАГ-ын ажиглалт**

Байгууллагын санхүүгийн тайланд 2016.01.01-ээр ХХОАТ-ын өглөг 380.1 мянган төгрөг, хувь хүнээс суутгасан албан татварын өглөг 686.5 мянган төгрөг байгаа боловч татварын мэдээгээр ХХОАТ-ын авлага 1,297.4 мянган төгрөг, хувь хүнээс суутгасан албан татварын авлага 297.8 мянган төгрөг байна. Нийт зөрүү 2,661.8 мянган төгрөг байна. Тайлант үеийн аудитаар залруулсан

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**ҮАГ-ын зөвлөмж**

Татварын байгууллагатай тооцоо нийлж татварын үлдэгдлийг байнга тохируулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөн ажиллах шаардлагатай байна. Өмнөх жилийн аудитаар яг ижил зөвлөмж гарсан боловч тайлант үед алдаа хэвээр байсаар байна.

**Гүйцэтгэх захирлын хариу**

Асуудлын бүртгэлд тусгаж байгууллагын холбогдох ажилтнуудад танилцуулж хариу авсан.

|                                              |                                  |
|----------------------------------------------|----------------------------------|
| <b>Асуудал 2: ХАОАТ-ын тооцооллын талаар</b> | <b>Тэргүүлэх ач холбогдол №3</b> |
|----------------------------------------------|----------------------------------|

**ҮАГ-ын ажиглалт**

НББ-ийн бодлогодоо Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалыг мөрдөж ажиллахаар оруулсан байна. Гэвч амралтын мөнгийг олгохдоо үндсэн цалин дээр хоол унааны мөнгийг нэмж тооцоолсон байна Үүнээс шалтгаалан ХАОАТ, НДШ-ийг илүү суутгахаас гадна ажилчдад илүү мөнгө олгогдсон байна. Дээрх алдаанууд нь нийлээд 1,367.5 мянган төгрөг болж байгаа ба компанийн материаллагаас хэтрээгүй тул зөвлөмж өгч залруулахыг санал болгов

**ҮАГ-ын зөвлөмж**

Ажилчдын амралтын мөнгийг дахин тооцоолж илүү олгосон амралтын мөнгө болон бусад түүнтэй холбоотой үүссэн алдааг 2017 оны 2-р сарын цалингийн тооцоололтой давхар хийж алдаагаа залруулах нь зүйтэй байна.

**Эрсдэлүүд**

Тушаал шийдвэр, НББ-ийн бодлогоо баримталж ажиллахгүй байна.

**Гүйцэтгэх захиралын хариу**

Асуудлын бүртгэлд тусгаж байгууллагын холбогдох ажилтнуудад танилцуулж хариу авсан.

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН  
УЛСЫН ЛАБОРАТОРИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН  
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөг/

| Үзүүлэлт                                | Тодруулга | Өмнөх он           | Залруулсан<br>үлдэгдэл |
|-----------------------------------------|-----------|--------------------|------------------------|
| <b>Эргэлтийн хөрөнгө</b>                |           |                    |                        |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө       | 3         | 35,153,385         | 47,225,453             |
| Дансны авлага                           | 4         | 13,502,867         | 36,280,105             |
| Татварын авлага                         |           | -                  | 769,932                |
| Бараа материал                          | 5         | 80,075,933         | 111,956,005            |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          |           | <b>128,732,185</b> | <b>196,231,497</b>     |
| <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>            |           |                    |                        |
| Үндсэн хөрөнгө                          | 6         | 847,908,722        | 724,410,212            |
| Биет бус хөрөнгө                        |           | 751,667            | 575,667                |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      |           | <b>848,660,388</b> | <b>724,985,878</b>     |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               |           | <b>977,392,573</b> | <b>921,217,375</b>     |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ</b>           |           |                    |                        |
| <b>Богино хугацаат өр төлбөр</b>        | 7         |                    |                        |
| Дансны өглөг                            |           | -                  | 15,671,507             |
| Татварын өглөг                          |           | 4,345,907          | 576,277                |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> |           | <b>4,345,907</b>   | <b>16,247,784</b>      |
| <b>Эзний өмч</b>                        |           |                    |                        |
| Хувьцаат капитал                        |           | 1,206,486,257      | 1,206,486,257          |
| Эзний өмчийн бусад хэсэг                |           | -                  | -                      |
| Өмнөх үеийн үр дүн                      |           | (441,955,728)      | (419,861,576)          |
| Тайлант үеийн үр дүн                    |           | 20,407,301         | (69,763,927)           |
| Дахин үнэлгээний нэмэгдэл               |           | 188,108,837        | 188,108,837            |
| <b>Эзний өмчийн дүн</b>                 |           | <b>973,046,667</b> | <b>904,969,591</b>     |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН</b>    |           | <b>977,392,573</b> | <b>921,217,375</b>     |

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН  
УЛСЫН ЛАБОРАТОРИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН  
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/төгрөг/

| Үзүүлэлт                             | Тодруулга | Өмнөх он           | Тайлант он          |
|--------------------------------------|-----------|--------------------|---------------------|
| <b>Борлуулалтын орлого</b>           | <b>8</b>  | 309,337,107        | 416,002,485         |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг      |           | -                  | -                   |
| <b>Нийт ашиг</b>                     |           | <b>309,337,107</b> | <b>416,002,485</b>  |
| Түрээсийн орлого                     |           | -                  | -                   |
| Хүүний орлого                        |           | 1,604,596          | 2,967,326           |
| Бусад орлого                         |           | -                  | -                   |
| Ерөнхий удирдлагын зардал            | <b>9</b>  | 278,149,247        | 474,408,656         |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз |           | -                  | -                   |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз  |           | -                  | -                   |
| Бусад                                |           | 9,105,910          | 14,714,898          |
| <b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>    |           | <b>23,686,546</b>  | <b>(70,153,744)</b> |
| Орлогын албан зардал                 |           | 3,279,246          | 296,733             |
| <b>ТАТВАРЫН ДАРААХ АШИГ</b>          |           | <b>20,407,301</b>  | <b>(70,450,476)</b> |

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН  
УЛСЫН ЛАБОРАТОРИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН  
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/төгсөг/

| Үзүүлэлт                                        | Өмч                  | Дахин үнэлгээний<br>нөөц | Эзний өмчийн<br>бусад хэсэг | Хуримтлагдсан<br>ашиг | Нийт дүн            |
|-------------------------------------------------|----------------------|--------------------------|-----------------------------|-----------------------|---------------------|
| <b>2015 оны 03 сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>   | 1,206,486,257        | 188,108,837              | -                           | (524,695,965)         | <b>869,899,129</b>  |
| Нягтлан бодох бүртгэлийн<br>өөрчлөлт, залруулга | -                    | -                        | -                           | 82,740,237            | <b>82,740,237</b>   |
| Ногдол ашиг                                     | -                    | -                        | -                           | -                     | -                   |
| Тайлант үеийн үр дүн                            | -                    | -                        | -                           | 20,407,301            | <b>20,407,301</b>   |
| <b>2015 оны 12 сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>   | <b>1,206,486,257</b> | <b>188,108,837</b>       | -                           | <b>(421,548,427)</b>  | <b>973,046,667</b>  |
| Нягтлан бодох бүртгэлийн<br>өөрчлөлт, залруулга | -                    | -                        | -                           | 2,373,400             | <b>2,373,400</b>    |
| Өмчид гарсан өөрчлөлт                           | -                    | -                        | -                           | -                     | -                   |
| Ногдол ашиг                                     | -                    | -                        | -                           | -                     | -                   |
| Тайлант үеийн үр дүн                            | -                    | -                        | -                           | (70,450,476)          | <b>(70,450,476)</b> |
| <b>2016 оны 12 сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>   | <b>1,206,486,257</b> | <b>188,108,837</b>       | -                           | <b>(489,625,503)</b>  | <b>904,969,591</b>  |

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН  
УЛСЫН ЛАБОРАТОРИ ТӨААТҮГ-ЫН АУДИТ ХИЙГДСЭН  
2016 ОНЫ ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/төгрөг/

| <b>Үзүүлэлт</b>                                                | <b>Өмнөх он</b>    | <b>Тайлант он</b>  |
|----------------------------------------------------------------|--------------------|--------------------|
| <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>                    |                    |                    |
| Борлуулалт болон худалдан авагчдаас орсон мөнгө                | 224,288,441        | 387,018,914        |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө                         | 5,646,430          | 1,337,900          |
| Бусад орлого                                                   | 109,518,637        |                    |
| <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</b>               | <b>339,453,508</b> | <b>388,356,814</b> |
| <b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>                         |                    |                    |
| <b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>                      |                    |                    |
| Цалин                                                          | 148,270,277        | 161,141,888        |
| <b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>                             |                    |                    |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл                              | 45,181,041         | 43,227,552         |
| <b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>                       |                    |                    |
| <b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>                         |                    |                    |
| Түүхий, эд материал худалдан авахад төлсөн мөнгө               | 27,756,411         | 105,129,337        |
| Түлш шатахуунд төлсөн мөнгө                                    | 4,316,500          | 339,250            |
| Ашиглалтанд төлсөн мөнгө                                       | 18,565,859         | 1,143,104          |
| Төлсөн татвар                                                  | 18,955,198         | 22,262,026         |
| Төлсөн хүү                                                     | 55,233             | -                  |
| Даатгалын төлбөрт төлсөн                                       | 112,332            | 124,830            |
| Бусад                                                          | 69,611,584         | 56,994,093         |
| <b>Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</b>                     | <b>332,824,435</b> | <b>390,362,081</b> |
| <b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>                    | <b>6,629,073</b>   | <b>(2,005,267)</b> |
|                                                                |                    |                    |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>       |                    |                    |
| Худалдаж авсан биет бус хөрөнгө                                | 660,000            | 749,990            |
| Бусдад олгосон зээл                                            | 760,000            | -                  |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b> | <b>1,420,000</b>   | <b>749,990</b>     |
|                                                                |                    |                    |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>               |                    |                    |
| Зээл авсан                                                     | 20,000,000         | 11,860,000         |
| Зээлийн төлбөрт төлсөн мөнгө                                   | 20,000,000         | -                  |
| Хүүгийн орлого                                                 | 1,604,596          | 2,967,326          |
| Нийгмийн даатгалаас орж ирсэн актны мөнгө                      | -                  | -                  |
| Мөнгөөр төлсөн ногдол ашиг                                     | -                  | -                  |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>         | <b>1,604,596</b>   | <b>14,827,326</b>  |
|                                                                |                    |                    |
| <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                               | <b>6,813,669</b>   | <b>12,072,069</b>  |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>        | <b>28,339,715</b>  | <b>35,153,385</b>  |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>       | <b>35,153,385</b>  | <b>47,225,453</b>  |